



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ӨНӨР БҮЛ ХҮҮХДИЙН ТӨВИЙН 2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,  
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: АХГ-2022/236/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг  
дараах хаягаар авна уу.



Аудитын хоёрдугаар газрын захирал, тэргүүлэх  
аудитор Ц.Наранчимэг  
Утас: 261663 Цахим хаяг: [naranchimegts@audit.gov.mn](mailto:naranchimegts@audit.gov.mn)  
Аудитын менежер: Б.Сэржмядаг  
Утас: 261628 Цахим хаяг: [serjmyadagb@audit.gov.mn](mailto:serjmyadagb@audit.gov.mn)  
Аудитор: Н.Баттөгөлдөр  
Утас: 261628 Цахим хаяг: [battuguldurn@audit.gov.mn](mailto:battuguldurn@audit.gov.mn)  
Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Их наяд аудит ХХК  
Захирал: Х.Ариунзул  
Утас: 11-450410 Цахим хаяг: [ikhnayadaudit@gmail.com](mailto:ikhnayadaudit@gmail.com)

Улаанбаатар хот  
2022 он

## Агуулга

Агуулга.....	1
1. Аудитын санал, дүгнэлт.....	4
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл.....	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	6
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	8
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	9
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	11
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	13
3. Аудитын тайлан.....	14
3.1 Ерөнхий зүйл.....	14
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт.....	14
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	15
3.4 Материаллаг байдал.....	15
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга.....	15
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	16
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг.....	17
3.8 Аудитын гол асуудал.....	17
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	17
3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	18
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	19
4. Аудитын илрүүлэлт.....	20
4.1 Залруулсан алдаа.....	20
4.2 Албан шаардлага.....	20
4.3 Зөвлөмж.....	20
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл.....	22
Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:.....	23

### Товчилсон үгийн жагсаалт

АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт



## ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг  
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр  
Утас:26-04-37, Факс:51-26-42-30  
E-mail: info@audit.gov.mn

ӨНӨР БҮЛ ХҮҮХДИЙН ТӨВИЙН  
ДАРГА М.ӨЛЗИЙЧИМЭГ ТАНАА

2022.02.24 № 07/303  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-г

### Аудитын санал дүгнэлт

#### Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Өнөр бүл хүүхдийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Өнөр бүл хүүхдийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

#### Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

## 2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>209,209,667.52</u></b>	<b><u>200,267,240.28</u></b>
34	УРЬДЧИЛГАА	16,212,510.00	
34600	Урьдчилж гарсан зардал	16,212,510.00	
35	БАРАА МАТЕРИАЛ	192,997,157.52	200,267,240.28
351	Түүхий эд материал	6,060,290.45	3,211,050.45
35110	Тусгай зориулалттай материал	3,030,000.00	3,030,000.00
35130	Эм боох материал	3,030,290.45	181,050.45
354	Хангамжийн материал	186,936,867.07	197,056,189.83
35410	Бичиг хэргийн материал	2,276,250.00	2,736,380.00
35420	Аж ахуйн материал	372,060.00	3,737,450.00
35430	Сэлбэг хэрэгсэл	803,000.00	2,547,000.00
35440	Түлш, шатах тослох материал	-	3,445,956.75
35450	Барилгын засварын материал		519,000.00
35460	Хүнсний материал	87,961,071.07	124,425,803.08
35470	Бусад хангамжийн материал	95,524,486.00	59,644,600.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>7,648,842,764.98</u></b>	<b><u>7,580,437,765.01</u></b>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	7,648,842,764.98	7,580,437,765.01
392	Биет хөрөнгө	7,169,605,204.98	7,101,200,205.01
39201	Барилга, байгууламж, орон сууц	7,566,610,103.00	7,670,825,203.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	(648,352,876.25)	(843,716,747.47)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	284,998,000.00	284,998,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(217,832,166.38)	(251,019,638.54)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	620,865,363.55	624,804,511.55
39206	Хуримтлагдсан элэгдэл	(546,388,205.19)	(541,272,626.32)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	209,971,514.00	270,897,114.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	(181,820,961.23)	(182,756,236.43)
39214	Бусад үндсэн хөрөнгө	152,009,451.00	167,069,451.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	(75,484,545.52)	(103,658,353.78)
39217	Ном	5,029,528.00	5,029,528.00
393	Биет бус хөрөнгө	479,237,560.00	479,237,560.00
39303	Бусад биет бус хөрөнгө	479,237,560.00	479,237,560.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>7,858,052,432.50</u></b>	<b><u>7,780,705,005.29</u></b>
<b>4</b>	<b>НИЙТ ӨР ТӨЛБӨР</b>	<b>-</b>	<b><u>1,933,480.00</u></b>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	-	1,933,480.00
413	Өглөг	-	1,933,480.00
4132	Бараа үйлчилгээний зардлын өглөг		1,933,480.00
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>7,858,052,432.50</u></b>	<b><u>7,778,771,525.29</u></b>
51	Засгийн газрын хувь оролцоо	7,858,052,432.50	7,778,771,525.29
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,746,814,042.00	1,746,814,042.00
51101	Өмч: - төрийн	1,746,814,042.00	1,746,814,042.00
512	Хуримтлагдсан үр дүн	3,233,335,487.95	3,149,054,580.74
51210	Өмнөх үеийн үр дүн	3,753,831,105.30	3,233,335,487.95
51220	Тайлант үеийн үр дүн	(525,495,617.35)	(84,280,907.21)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,882,902,902.55	2,882,902,902.55
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>7,858,052,432.50</u></b>	<b><u>7,780,705,005.29</u></b>

**2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан**

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>2,459,050,110.00</b>	<b>2,690,454,276.00</b>
<b>12</b>	<b>ТАТВАРЫН БУС ОРЛОГО</b>	<b>698,610.00</b>	<b>201,989,076.00</b>
120	Нийтлэг татварын бус орлого	698,610.00	201,989,076.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	698,610.00	201,989,076.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	698,610.00	201,989,076.00
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>2,458,351,500.00</b>	<b>2,488,465,200.00</b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,446,311,500.00	2,446,777,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,446,311,500.00	2,446,777,200.00
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>12,040,000.00</b>	<b>41,688,000.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,040,000.00	41,688,000.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>2,984,545,727.35</b>	<b>2,774,599,766.85</b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,984,545,727.35	2,774,599,766.85
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,926,512,915.67	2,703,545,316.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,314,361,461.62	1,327,035,067.03
210101	Үндсэн цалин	784,412,506.62	831,515,859.44
210102	Нэмэгдэл	428,236,955.00	390,463,582.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	101,712,000.00	105,055,625.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	177,504,500.00	173,113,047.00
210201	Тэтгэврийн даатгал	124,910,600.00	120,519,047.00
210202	Тэтгэмжийн даатгал	13,148,400.00	13,148,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,518,800.00	10,518,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,629,700.00	2,629,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,297,000.00	26,297,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,233,120.11	99,251,780.00
210301	Гэрэл, цахилгаан	39,750,807.00	38,637,300.76
210302	Түлш, халаалт	48,486,055.69	43,583,620.51
210303	Цэвэр, бохир ус	24,996,257.42	17,030,858.73
2104	Хангамж, бараа материалын зардал	60,644,155.89	81,103,641.06
210401	Бичиг хэрэг	13,156,158.30	10,051,955.00
210402	Тээвэр, шатахуун	15,949,100.00	17,633,921.25
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	755,520.59	599,756.81
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	8,366,000.00	9,526,440.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	22,417,377.00	43,291,568.00
2105	Нормативт зардал	672,437,127.53	673,410,662.99
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,572,488.30	11,357,120.00
210502	Хоол, хүнс	513,904,980.83	498,648,214.99
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	151,959,658.40	163,405,328.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	13,693,270.00	9,984,050.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,247,753.00	628,000.00
210604	Урсгал засвар	9,445,517.00	9,356,050.00
2107	Томилолт, зочны зардал	1,002,000.00	
210702	Дотоод албан томилолт	1,002,000.00	

**Өнөр бүл хүүхдийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,658,088.00	11,562,257.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,109,594.00	5,009,457.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,520,000.00	3,520,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,799,724.00	1,800,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	632,400.00	666,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	246,370.00	216,400.00
210807	Газрын төлбөр	350,000.00	350,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	564,979,192.52	328,084,811.61
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	674,600.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,087,610.00	38,584,660.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	559,216,982.52	289,500,151.61
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>58,032,811.68</b>	<b>71,054,450.16</b>
2132	Бусад урсгал шилжүүлэг	52,443,265.00	69,412,624.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	48,187,652.00	69,412,624.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,255,613.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,589,546.68	1,641,826.16
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,589,546.68	1,641,826.16
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(525,495,617.35)</u></b>	<b><u>(84,145,490.85)</u></b>
<b>145</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГЫН ДҮН</b>	-	-
	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРЛАГЫН ДҮН</b>		135,416.36
	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		135,416.36
<b>4</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)</b>	-	(135,416.36)
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(525,495,617.35)</u></b>	<b><u>(84,280,907.21)</u></b>



### 2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
<b>2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	1,746,814,042.00	2,883,479,466.55	3,753,831,105.30	8,384,124,613.85
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,746,814,042.00</b>	<b>2,883,479,466.55</b>	<b>3,753,831,105.30</b>	<b>8,384,124,613.85</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	(576,564.00)	-	(576,564.00)
Тайлант үеийн үр дүн	-	-	(520,495,617.35)	(525,495,617.35)
<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,746,814,042.00</b>	<b>2,882,902,902.55</b>	<b>3,233,335,487.95</b>	<b>7,863,052,432.50</b>
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
<b>Дахин илэрхийлсэн үлдэгдэл</b>	<b>1,746,814,042.00</b>	<b>2,882,902,902.55</b>	<b>3,233,335,487.95</b>	<b>7,863,052,432.50</b>
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
Тайлант үеийн үр дүн	-	-	(84,280,907.21)	(84,280,907.21)
<b>2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>1,746,814,042.00</b>	<b>2,882,902,902.55</b>	<b>3,149,054,580.74</b>	<b>7,778,771,525.29</b>

## 2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b><u>2,458,351,500.00</u></b>	<b><u>2,493,465,200.00</u></b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b><u>2,458,351,500.00</u></b>	<b><u>2,493,465,200.00</u></b>
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,446,311,500.00	2,446,777,200.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,446,311,500.00	2,446,777,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	12,040,000.00	46,688,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	12,040,000.00	46,688,000.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b><u>2,458,351,500.00</u></b>	<b><u>2,493,465,200.00</u></b>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,458,351,500.00	2,493,465,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,396,615,540.32	2,422,410,749.84
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,314,361,461.62	1,322,643,514.03
210101	Үндсэн цалин	784,412,506.62	827,124,306.44
210102	Нэмэгдэл	428,236,955.00	390,463,582.54
210103	Унаа хоолны хөнгөлөлт	101,712,000.00	105,055,625.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	177,504,500.00	177,504,600.00
210201	Тэтгэврийн даатгал	124,910,600.00	124,910,600.00
210202	Тэтгэмжийн даатгал	13,148,500.00	13,148,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	10,518,800.00	10,518,800.00
210204	Ажилгүйдлийн даатгал	2,629,700.00	2,629,700.00
210205	Эрүүл мэндийн даатгал	26,297,000.00	26,297,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,233,120.11	97,318,300.00
210301	Гэрэл, цахилгаан	39,750,807.00	36,703,820.76
210302	Түлш, халаалт	48,486,055.69	43,583,620.51
210303	Цэвэр, бохир ус	24,996,257.42	17,030,858.73
2104	Хангамж, бараа материалын зардал	75,591,887.59	51,745,096.81
210401	Бичиг хэрэг	10,252,600.00	5,778,490.00
210402	Тээвэр, шатахуун	23,287,000.00	4,725,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	940,520.59	799,406.81
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,971,900.00	10,996,740.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	31,139,867.00	29,444,860.00
2105	Нормативт зардал	667,214,083.00	684,065,262.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,496,498.00	8,226,695.00
210502	Хоол, хүнс	513,233,100.00	535,101,947.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	144,484,485.00	140,736,620.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	29,423,900.00	13,636,100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	4,518,800.00	3,715,000.00
210604	Урсгал засвар	24,905,100.00	9,921,100.00
2107	Томилолт, зочны зардал	1,002,000.00	
210702	Дотоод албан томилолт	1,002,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	10,169,288.00	32,849,277.00

**Өнөр бүл хүүхдийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	3,620,794.00	26,296,477.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,520,000.00	3,520,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,799,724.00	1,800,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	632,400.00	666,400.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	246,370.00	216,400.00
210807	Газрын төлбөр	350,000.00	350,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	8,115,300.00	42,648,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	674,600.00	
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,440,700.00	42,648,600.00
213	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	61,735,959.68	71,054,450.16
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,146,413.00	69,412,624.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	51,890,800.00	69,412,624.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,255,613.00	
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	5,589,546.68	1,641,826.16
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	5,589,546.68	1,641,826.16
<b>3</b>	<b>Үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>	-	-
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	-	-
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	-	-

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	2,446,777,200.00	2,445,135,373.84	1,641,826.20
<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	2,446,777,200.00	2,445,135,373.84	1,641,826.20
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,376,558,400.00	2,375,722,749.84	835,650.16
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,314,848,900.00	1,314,843,514.03	5,385.97
Үндсэн цалин	865,005,300.00	819,324,306.44	45,680,993.56
Нэмэгдэл	348,131,600.00	390,463,582.54	(42,331,982.54)
Унаа хоолны хөнгөлөлт	101,712,000.00	105,055,625.05	(3,343,625.05)
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	177,504,600.00	177,504,600.00	-
Тэтгэврийн даатгал	124,910,600.00	124,910,600.00	-
Тэтгэмжийн даатгал	13,148,500.00	13,148,500.00	-
ҮОМШӨ-ний даатгал	10,518,800.00	10,518,800.00	-
Ажилгүйдлийн даатгал	2,629,700.00	2,629,700.00	-
Эрүүл мэндийн даатгал	26,297,000.00	26,297,000.00	-
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	97,318,300.00	97,318,300.00	-
Гэрэл, цахилгаан	35,453,600.00	36,703,820.76	(1,250,220.76)
Түлш, халаалт	44,601,300.00	43,583,620.51	1,017,679.49
Цэвэр, бохир ус	17,263,400.00	17,030,858.73	232,541.27
Хангамж, бараа материалын зардал	49,057,100.00	49,057,096.81	3.19
Бичиг хэрэг	6,076,500.00	5,778,490.00	298,010.00
Тээвэр, шатахуун	4,725,600.00	4,725,600.00	-
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,511,500.00	799,406.81	712,093.19
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	9,224,200.00	10,996,740.00	(1,772,540.00)
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	27,519,300.00	26,756,860.00	762,440.00
Нормативт зардал	684,079,400.00	684,065,262.00	14,138.00
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	8,230,300.00	8,226,695.00	3,605.00
Хоол, хүнс	535,102,000.00	535,101,947.00	53.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	140,747,100.00	140,736,620.00	10,480.00
Эд хогшил, урсгал засварын зардал	13,636,100.00	13,636,100.00	-
Багаж, техник, хэрэгсэл	3,715,000.00	3,715,000.00	-
Урсгал засвар	9,921,100.00	9,921,100.00	-
Томилолт, зочны зардал	816,000.00		816,000.00
Дотоод албан томилолт	816,000.00		816,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	32,849,400.00	32,849,277.00	123.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	26,296,600.00	26,296,477.00	123.00
Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	3,520,000.00	3,520,000.00	-

Өнөр бүл хүүхдийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Даатгалын үйлчилгээ	1,800,000.00	1,800,000.00	-
Тээврийн хэрэгслийн татвар	632,800.00	666,400.00	(33,600.00)
Тээврийн хэрэгслийн оношлогоо	250,000.00	216,400.00	33,600.00
Газрын төлбөр	350,000.00	350,000.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал	6,448,600.00	6,448,600.00	-
Бараа үйлчилгээний бусад зардал			
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,448,600.00	6,448,600.00	-
<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>70,218,800.00</b>	<b>69,412,624.00</b>	<b>806,176.00</b>
Бусад урсгал шилжүүлэг	70,218,800.00	69,412,624.00	806,176.00
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	70,218,800.00	69,412,624.00	806,176.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>2,446,777,200.00</b>	<b>2,445,135,373.84</b>	<b>1,641,826.20</b>
<b>УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	<b>2,446,777,200.00</b>	<b>2,445,135,373.84</b>	<b>1,641,826.20</b>
Улсын төсвөөс санхүүжих	2,446,777,200.00	2,445,135,373.84	1,641,826.20
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-
<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	<b>136</b>	<b>125</b>	<b>11</b>
Удирдах ажилтан	3	3	
Гүйцэтгэх ажилтан	87	76	11
Үйлчлэх ажилтан	46	46	

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>		46,688,000.00
УРСГАЛ ЗАРДАЛ		46,688,000.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		46,688,000.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал		7,800,000.00
Үндсэн цалин		7,800,000.00
Хангамж, бараа материалын зардал		2,688,000.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		2,688,000.00
Бараа үйлчилгээний бусад зардал		36,200,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		36,200,000.00
<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>		46,688,000.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		46,688,000.00
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт тусгагдсан төсвөөс доош шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		46,688,000.00
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		-
<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>		-

### 3. Аудитын тайлан

#### 3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Өнөр бүл хүүхдийн төвийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч байгууллагад жилийн эцсээр өр төлбөр үүсгэхгүй байх, бараа материал, хөрөнгийн эд хариуцагч бүрээр үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгаж байх талаар өгсөн зөвлөмжийг тусгасан болно.

Аудитыг 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрөөс 2022 оны 02 дугаар сарын 14-ний өдрийн хооронд Их наяд аудит ХХК-ийн аудитор Х.Ариунтуяа, аудиторын туслах С.Бямбацэцэг нар гүйцэтгэж, захирал Х.Ариунзул чанарын хяналтыг хэрэгжүүлсэн.

Өнөр бүл хүүхдийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Их наяд аудит ХХК-д 2022 оны 01 дүгээр сарын 13-ний өдрийн 08 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн байна.

#### 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Өнөр бүл хүүхдийн төвийн зорилго нь Хүүхдийн эрхийг дээдлэн хүндэлж, оролцоонд тулгуурлан бүтээлч сэтгэлгээ, амьдрах ухааны чадварыг эзэмшүүлэх, хүүхэд бүрийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг хангахад оршино.

Тус төв нь байгууллагынхаа үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

Чиг үүрэг: 02-18 хүртэлх насны бүтэн өнчин, хаягдсан, эцэг эх нь сэтгэцийн өвчтэй, хөдөлмөрийн чадвараа 70-аас дээш хувиар алдсан нь тогтоогдсон, эцэг эх байх эрхээ шүүхийн шийдвэрээр хязгаарлуулсан, хасуулсан гэр бүлийн хүүхдийг авч гэр бүлд дүйцэхүйц хөгжил, хамгааллын болон хүүхэд асрах хувилбарт үйлчилгээ үзүүлэх.

Үйл ажиллагааны чиглэл: Хүүхэд бүрийг аюулгүй орчинд бүрэн хамгаалж эсэн мэнд амьдрах, хөгжих хамгаалуулах, оролцох эрхийг хангах гэр бүлтэй дүйцэх орчинд амьдарч, хөгжих боломж бүрдүүлэн, насанд хүрч бие даан амьдрахад бэлтгэх, хүүхэд хамгааллын цогц үйлчилгээ үзүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрдөх хууль, тогтоомж, бодлого чиглэлд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2021 оны 124 дүгээр тогтоол “Босго үнэ шинэчлэн батлах тухай”;
- Сангийн сайдын 2021 оны 190 дүгээр тушаал “Зардлын эдийн засгийн ангилал ашиглах заавар”

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тайлант онд Өнөр бүл хүүхдийн төвд дээд шатны хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудит хийгдээгүй байна.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Өнөр бүл хүүхдийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Мөн төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хуулийн 54.5-д заасны дагуу бүрэлдэхүүн хэсгээр иж бүрэн бэлтгэж ирүүлээгүй байна.

### 3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,472,260.9 мянган төгрөгөөс 1.0 хувиар буюу 14,722.6 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

### 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Өнөр бүл хүүхдийн төвийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 77,347.4 мянган төгрөгөөр буюу 1.0 хувиар буурч материаллаг өөрчлөлт гарсан урьдчилгаа, бараа материал, өр төлбөр, үр дүнгийн данснууд байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/Мянган төгрөг/			
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Урьдчилгаа	16,212.5		(16,212.5)
Бараа материал	192,997.2	200,267.2	7,270.0
Үндсэн хөрөнгө	7,648,842.8	7,580,437.7	(86,405.1)
<b>Нийт хөрөнгө</b>	<b>7,858,052.4</b>	<b>7,780,705.0</b>	<b>(77,347.4)</b>
Өр төлбөр		1,933.5	1,933.5
Засгийн газрын оролцоо /эздийн өмч/	<b>7,858,052.4</b>	7,778,771.5	(79,280.9)
<b>Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн</b>	<b>7,858,052.4</b>	<b>7,780,705.0</b>	<b>(77,347.4)</b>

Дансны үлдэгдэлд гарсан материаллаг дүнтэй дараах өөрчлөлтүүд байна. Үүнд:

- Урьдчилгаа төлбөрийн 16,212.5 мянган төгрөгийн шатахууныг бараа материал дансанд шилжүүлэн бүртгэсэн;
- Бараа материалын дансны үлдэгдэл нь хандиваар авсан бараа материал 4,443.0 мянган төгрөг, худалдан авалтаар 751,644.5 мянган төгрөгөөр нэмэгдэж, 723,168.9 мянган төгрөгийн бараа материал зарцуулж, 25,648.5 мянган төгрөгийн бараа материалыг акталж даснаас хассан;
- Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь Нийслэлийн Өмчийн ашиглалт, удирдлагын газрын 2021 оны А/237 дугаар тушаалын дагуу 37,090.7 мянган төгрөгийн биет хөрөнгийг акталж данснаас хассан ба тайлант жилийн элэгдлийн зардалтай холбоотой.
- Өр төлбөрийн дансны 1,933.5 мянган төгрөгийн үлдэгдэл нь УБЦТС ТӨХК-д төлж барагдуулаагүй гэрэл цахилгааны төлбөрийн үлдэгдэл байна.



Өнөр бүл хүүхдийн төвийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 231,404.2 мянган төгрөгөөр буюу 9.4 хувиар өссөн нь үнэ төлбөргүй хүлээн авсан орлогын 201,290.5 мянган төгрөгийн материаллаг өсөлтөөс шалтгаалжээ.

Нийт зардал өмнөх оноос 209,945.9 мянган төгрөгөөр буюу 7.0 хувиар буурчээ. Өмнөх оны үзүүлэлтээс цалин хөлс, хангамж, бараа материал, нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөрийн зардлууд өссөн боловч, байр ашиглалт, эд хогшил урсгал засвар, томилолт, зочны зардал, бараа үйлчилгээний бусад зардлууд материаллаг хэмжээгээр хэмнэсэнтэй холбоотой байна.

### 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,511,281.4 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,511,281.4 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс Сангийн яам 64,504.2 мянган төгрөгөөр бууруулан 2,446,777.2 мянган төгрөгөөр баталсан ба төсвийн тодотгол хийгдээгүй байна.

#### 3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 02-18 насны хүүхэд асран хамгаалах 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,446,777.2 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,446,777.2 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 2,445,135.4 мянган төгрөгийг зарцуулж 1,641.8 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна.

*Хүснэгт-3 Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	72207	Төсөв гүйцэтгэгчээс	2,446,777.2	2,445,135.4	1,641.8	99.9
1.1	80101	Үйл ажиллагааны урсгал зардал	2,376,558.4	2,375,722.7	835.7	99.9
1.2	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	70,218.8	69,412.6	806.2	98.9

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,445,135.4 мянган төгрөг буюу 99.9 хувьтай байгаа нь бараа ажил үйлчилгээний зардал 835.7 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлэг 806.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

#### 3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Нийслэлийн гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн газраас хэрэгжүүлэх хөтөлбөрийн хүрээнд 46,688.0 мянган төгрөгийн орлогыг төвлөрүүлжээ.

Үүнээс цалин хөлс болон нэмэгдэл урамшилд 7,800.0 мянган, хангамж, бараа материалын зардалд 2,688.0 мянган, бараа үйлчилгээний бусад зардалд 36,200.0 мянган төгрөгийг тус тус зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

### **3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг**

Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/111 дүгээр тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас 2021-2022 онд гүйцэтгэх санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл”-ийн дагуу шалгагдагч байгууллагыг тулган шалгахад анхаарах асуудал гараагүй байна.

Тайлант онд хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээ нийт 2,446,777.2 мянган төгрөг. Үүнд:

- Төвийн үйлчилгээнд хамрагдаж байгаа 02-18 хүртэлх насны хүүхдүүдийн амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдлыг бүрэн хангаж, гэр бүлийн орчинд дүйцэхүйц ээлтэй орчныг сайжруулах, амьдрах ухаанд сургах, зөв дадал хэвшил олгоход 2,420,568.2 мянган төгрөг;
- Хүүхэд бүрийг нийгмийн ажлын, эрүүл мэндийн болон сэтгэл зүйн нөхөн сэргээх, урьдчилан сэргийлэх, хүүхэд хамгааллын цогц үйлчилгээнд хамруулахад 209.0 мянган төгрөг;
- Хүүхэд бүрийн хөгжлийг дэмжин, оролцоог хангах, авьяас, чадварыг нээн хөгжүүлэхэд 14,000.0 мянган төгрөг;
- Ажилтан, албан хаагчдын хүүхдийн эрхийг хамгаалах, хүүхдэдээ тавих анхаарал, халамжийг сайжруулах, байгууллагын залуучуудын нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх, залуучуудын хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд 6,000.0 мянган төгрөг;
- Удирдлага зохион байгуулалт, хүний нөөцийн үйл ажиллагааг сайжруулах, байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангах хөтөлбөрт 6,000.0 мянган төгрөг тус тус байна.

### **3.8 Аудитын гол асуудал**

Төрөлжсөн асрамжийн үйлчилгээнд хамрагдаж байгаа хүүхдүүдийн хоол хүнсний нэг хүүхдэд ногдох норм, илчлэгийн хэмжээ, зардлын дундаж нормативыг 2013 онд Сангийн сайд, Хүн амын хөгжил, Нийгмийн хамгааллын сайдын тушаалаар баталсан ба 2016 онд ахин хэвээр баталсан байна. Уг нормативын зардал нь 2017 онд батлагдсан хүүхэд асрах хувилбарт үйлчилгээнд тавигдах шаардлага MNS5852:2017 стандарттай зөрчилдөж байгаа тул хүүхдүүдийн хоол хүнсний норм, нормативыг шинэчлэх талаар тус төвийн удирдлага анхаарч, цаашид шаарлагатай арга хэмжээг авч ажиллах шаардлагатай.

### **3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

#### **3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1, 3.1.2-т хамаарах төсөвт байгууллага, төрийн болон орон нутгийн өмчит үйлдвэрийн газар нь 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т тус тус тусгасан мэдээллийг хуульд заасан хугацаанд ил тод мэдээлэх зохицуулалттай.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан дараах 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 1,728,351,600 төгрөгийн 50 мэдээллийг хугацаа хоцроож зөрчлийг давтан гаргаж өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Шилэн дансны тухай хуулийг мөрдөж, мэдээллийг хугацаанд нь иж бүрэн байршуулах, нягтлан бодогч Б.Долзодмаад хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлэх.

### 3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төсөвт зардлыг хэмнэж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж батлагдсан урсгал зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна.

Энэ нь "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах албан шаардлага хүргүүлэх.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй, Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй байна гэж дүгнэлээ.

### 3.10 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Завсрын аудитаар нийт 61,849.6 мянган төгрөгийн алдаа зөрчилд 5 зөвлөмж өгч жилийн эцсийн аудитаар дахин хянахад 61,849.6 мянган төгрөгийн 5 зөвлөмжийг хэрэгжүүлсэн.

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2,888.1 мянган төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн актыг төлж, 259,538.9 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг 70 хувь, 27,626.5 мянган төгрөгийн 5 зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

Хүснэгт 3. Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт:

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	2,888.1	1	2,888.1			100%
Албан шаардлага	2	259,538.9	1	259,538.9			70%
Зөвлөмж	5	27,626.5	5	27,626.5			100%
<b>Нийт дүн</b>	<b>8</b>	<b>290,053.5</b>	<b>7</b>	<b>290,053.5</b>			<b>90%</b>

Шилэн дансны тухай хуулийн зөрчилд өгсөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш 37 гүйлгээг мэдээлээгүй зөрчлийг арилгаж холбогдох мэдээллийг хоцроон байршуулсан зөрчлийг давтан гаргасан байна.

### 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар дараах асуудлуудыг анхаарч авч үзнэ. Үүнд:

- Тус төв нь хүүхдийн хөгжих эрхийг хангах, бие бялдрын болон чөлөөт цагаа өнгөрүүлэх, нийгэмшихүйн хөгжлийг дэмжих зорилгоор Монгол телевизийн уран бүтээл “Ододтой бүжиглэе” шоу нэвтрүүлгийн ялагч Б.Баттөр буюу Ангуучийн шинээр байгуулж байгаа Жижүцү бие хамгаалах урлагийн клубийн үйл ажиллагаанд Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн сангийн санхүүжилтээр олгогдсон 9,930.0 мянган төгрөгийн санхүүжилтийг санхүүгийн тайланд толилуулсан байна. Гэтэл тайлант жилд тус клубийн үйл ажиллагаа хэвийн явагдаж байгаа ба клубийн бүртгэгдээгүй хөрөнгийг авч үзэх.
- Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүнгийн чанарын болон тоон үзүүлэлтийн хэрэгжилтийг гаргаж, түүний танилцуулгыг бэлтгэсэн эсэхийг авч үзэх.

#### 4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 112,897.0 мянган төгрөгийн 8 алдаа зөрчил илэрснээс, 107,933.5 мянган төгрөгийн 3 алдааг залруулж, 2 албан шаардлага хүргүүлж, 4,963.5 мянган төгрөгийн алдаа зөрчилд 2 зөвлөмж өглөө.

Залруулагдаагүй 4,963.5 мянган төгрөгийн алдаа зөрчил нь тогтоосон материаллаг байдлын түвшинээс 9,759.1 мянган төгрөгөөр бага байгаа тул Зөрчилгүй дүгнэлт өглөө.

##### 4.1 Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ И баримтыг 4,473.1 мянган төгрөгөөр дутуу бүрдүүлсэн.
2. Хандиваар авсан 3,945.3 мянган төгрөгийн бараа материалыг санхүүгийн тайлан балансад тусгаагүй.
3. "Инносолошн" ХХК-тай гэрээ байгуулан цэцэрлэгийн барилгын бохирын хоолойг солих засварын ажил гүйцэтгүүлж 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ажил хүлээлцэх акт үйлдсэн боловч тайлант онд хөрөнгө капиталжуулж санхүүгийн тайланд 99,515.1 мянган төгрөгийг тусгаагүй.

##### 4.2 Албан шаардлага

Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулгыг бэлтгэж, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгээгүй.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна: 54.5.4 хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй, иж бүрэн байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгэж, Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах, албан шаардлага хүргүүлэх.

##### 4.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

###### 1. **Балансын данстай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

УБЦТС ТӨХК-нд 2021.12.31-ний өдрөөр 1,933.5 мянган төгрөгийн гэрэл цахилгааны тооцооны өр төлбөр гарсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.8. "төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх" гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

###### Өгсөн зөвлөмж:

Төсвийг зохистой удирдаж, жилийн эцсийн анхүүгийн тайлангаар өр үүсгэхгүй байх.

###### 2. **Балансын данстай холбоотой асуудал**

###### Илрүүлэлт:

Жилийн эцсийн үлдэгдэлд өөрчлөлт ороогүй 3,030.0 мянган төгрөгийн бараа материалыг тооллогын бүртгэлд тусгаагүй зөрүүтэй байгаа нь Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 71.1. "Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч, ерөнхий нягтлан бодогч нь тооллого эхлэхийн өмнө дараах бэлтгэл хангасан байх үүрэгтэй; 71.1.2 "бараа, материал, үнэ бүхий зүйлийн орлого, зарлагыг цэгцлэн шалгаж, нэр төрлийн бүртгэлийг эд хариуцагч бүрээр хөтлүүлж тайлан гаргуулан үлдэгдлийн бүртгэлтэй тулган шалгасан

байх” гэсэн заалттай нийцээгүй, санхүүгийн тайлагналын иж бүрэн байх гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Тооллогын бүртгэлд тусгаагүй бараа материалыг эд хариуцагчаар бүртгэлжүүлж, тооллогын бүртгэлд тусгах.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

---

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

д/д	Байгууллагын нэр	Аудитын код	Алдаа, зөрчлийн товч утга	Нийт алдаа, зөрчлийн		Үүнээс									
						Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Хариуцлага тооцох		Зөвлөмж	
				Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайлангийн аудитын асуудал:															
1	Өнөр бүл хүүхдийн төвийн	АХГ-2022/236/НА-СТА-ТШЗ	Иргэд, аж ахуйн нэгж байгууллагуудаас худалдан авалт хийхдээ И баримтыг дутуу бүрдүүлсэн.	1	4,473.1	1	4,473.1								
2	Өнөр бүл хүүхдийн төвийн	АХГ-2022/236/НА-СТА-ТШЗ	Хандиваар авсан бараа материалыг санхүүгийн тайлан балансад тусгаагүй.	1	3,945.3	1	3,945.3								
3	Өнөр бүл хүүхдийн төвийн	АХГ-2022/236/НА-СТА-ТШЗ	"Инносолюшн" ХХК-тай гэрээ байгуулан цэцэрлэгийн барилгын бохирын хоолойг солих засварын ажил гүйцэтгүүлж 2021 оны 6 дугаар сарын 30-ны өдөр ажил хүлээлцэх акт үйлдсэн боловч тайлант онд хөрөнгө капиталжуулж санхүүгийн тайланд тусгаагүй.	1	99,515.1	1	99,515.1								
4	Өнөр бүл хүүхдийн төвийн	АХГ-2022/236/НА-СТА-ТШЗ	УБЦТС ТӨХК-нд 2021.12.31-ний өдрөөр гэрэл цахилгааны тооцооны өр төлбөр гаргасан.	1	1,933.5									1	1,933.5
5	Өнөр бүл хүүхдийн төвийн	АХГ-2022/236/НА-СТА-ТШЗ	Жилийн эцсийн үлдэгдэлд өөрчлөлт ороогүй бараа материалыг тооллогын бүртгэлд тусгаагүй зөрүүтэй.	1	3,030.0									1	3,030.0
6	Өнөр бүл хүүхдийн төвийн	АХГ-2022/236/НА-СТА-ТШЗ	Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулгыг бэлтгэж, төсвийн	1						1					

Өнөр бүл хүүхдийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд  
хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

			гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгээгүй.											
<b>Дүн</b>				<b>6</b>	<b>112,897.0</b>	<b>3</b>	<b>107,933.5</b>			<b>1</b>			<b>2</b>	<b>4,963.5</b>
<b>Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал:</b>														
1	Өнөр бүл хүүхдийн төвийн	АХГ- 2022/236/ НА-СТА- ТШЗ	Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 1,728,351,600 төгрөгийн 50 мэдээллийг хугацаа хоцроож зөрчлийг давтан гаргаж өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна	1						1		1		
2	Өнөр бүл хүүхдийн төвийн	АХГ- 2022/236/ НА-СТА- ТШЗ	Төсөвт зардлыг хэмнэж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж батлагдсан урсгал зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй.	1						1				
<b>Дүн</b>				<b>2</b>						<b>1</b>		<b>1</b>		
<b>Нийт дүн</b>				<b>8</b>	<b>112,897.0</b>	<b>3</b>	<b>107,933.5</b>			<b>3</b>		<b>1</b>	<b>2</b>	<b>4,963.5</b>





ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022

оны

02

дугаар сарын

25

№

161/A0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/256/НА-СН-ТМЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Өнөр бүл хүүхдийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Төсөвт зардлыг хэмнэж, төсвийн хөрөнгийг үр ашигтай зарцуулж батлагдсан урсгал зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргаж ажиллаагүй байна

Энэ "Төсвийн хэмнэлтийн талаар авах зарим арга хэмжээний тухай" Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.1 "үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал, төсөл, арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй байх зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдааг зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны 95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**


1. Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Өнөр бүл хүүхдийн төвийн дарга М.Өлзийчимэг, ерөнхий нягтлан бодогч Б.Долзодмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

*(Signatures)*

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ  
Х.АРИУНТУЯА



0010800577



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 162/А0150058  
АХГ-2022/236/НА-СТА-ТШЗ

Улаанбаатар хот

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Өнөр бүл хүүхдийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулгыг бэлтгэж, төсвийн гүйцэтгэлийн тайланг иж бүрэн бэлтгээгүй.

Энэ "Төсвийн тухай хуулийн 54 дүгээр зүйлийн 54.5 "Төсвийн гүйцэтгэлийн тайлан нь дараах бүрэлдэхүүн хэсэгтэй байна: 54.5.4.хөтөлбөр, арга хэмжээнд зарцуулсан төсөв, хүрсэн үр дүн, түүний танилцуулга" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төсвийн гүйцэтгэлийн тайланг хуулийн хугацаанд иж бүрэн бэлтгэж байх биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Өнөр бүл хүүхдийн төвийн дарга М.Өлзийчимэг, ерөнхий нягтлан бодогч Б.Долзодмаа нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ  
Х.АРИУНТУЯА



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА

2022 оны 02 дугаар сарын 25 № 163/А0150058

Улаанбаатар хот

АХГ-2022/236/НА-СТА-ТЦ/3

Сахилгын шийтгэл ногдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Өнөр бүл хүүхдийн төвийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант хугацаанд шилэн дансны нэгдсэн цахим хуудаст 1,728,351,600 төгрөгийн 50 мэдээллийг хугацаа хоцроож зөрчлийг давтан гаргаж өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2 "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3 "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангаагүй, өмнөх аудитаар өгсөн албан шаардлагыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3-т "Энэ хуулийн 42.1, 42.2-т заасан үндэслэл бүрдсэн тохиолдолд төрийн аудитын байгууллага тухайн албан хаагчид холбогдох сахилгын шийтгэл ногдуулах талаар эрх бүхий албан тушаалтанд албан шаардлага өгөх ба эрх бүхий албан тушаалтан ямар шийдвэр гаргасан талаараа албан шаардлагад заасан хугацаанд төрийн аудитын байгууллагад хариу мэдэгдэнэ", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Сахилгын шийтгэл ногдуулах албан шаардлага" хүргүүлэх журмын 4.2.2-т заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Шилэн дансны хуулийг хэрэгжүүлж ажиллаагүй, зөрчлийг давтан гаргасан нягтлан бодогч Б.Долзодмаад хуульд заасны дагуу сахилгын шийтгэл ногдуулж, биелэлтийг 2022 оны 9 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Өнөр бүл хүүхдийн төвийн дарга М.Өлзийчимэгт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН  
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  
АУДИТЫН МЕНЕЖЕР  
ИХ НАЯД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ  
Б.СЭРЖМЯДАГ  
Х.АРИУНТУЯА

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.20\Bichig\_Khereg\Alban\_Shaardlaga\2022\0225\_Auditin\_2\_Gazar-176.Docx

0010800580



## ТЭМДЭГЛЭЛ

A series of 27 horizontal dotted lines for writing.